

## **ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР**

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

### **Тавигдах болзол, шаардлага:**

- Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

### **Бүрдүүлэх материал:**

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/.

**ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АВАХ АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ: ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

**Материал хүлээн авах:**

- Хугацаа: **2026** оны **03** дугаар сарын **24**-ний өдрийн **17<sup>00</sup>** цаг хүртэл
- Хүлээн авах цахим хаяг: [sumiyabazar.m@gazar.gov.mn](mailto:sumiyabazar.m@gazar.gov.mn)
- Холбоо барих утас: 88964451, 80249898

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
					Төрөл	Ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
<b>ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР</b>										
<b>УДИРДАХ</b>										
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	Орон зайн өгөгдөл, дэд бүтцийн газар	Орон зайн өгөгдөл, дэд бүтцийн газрын дарга	1	Удирдах	Эрхэлсэн түшмэл ТЗ-3	Бакалавр ба түүнээс дээш	Газар зохион байгуулалт, газрын үнэлгээ, газрын кадастр 073101-073103, Геодези 053201.	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх.	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.
2	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	Хуулийн хэлтэс	Хуулийн хэлтсийн дарга	1	Удирдах	Ахлах түшмэл ТЗ-4	Бакалавр ба түүнээс дээш	Эрх зүй 042101.	Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх.	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.
3	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	Мэдээлэл, технологийн хэлтэс	Мэдээлэл, технологийн хэлтсийн дарга	1	Удирдах	Ахлах түшмэл ТЗ-4	Бакалавр ба түүнээс дээш	Газар зохион байгуулалт, газрын үнэлгээ, газрын кадастр 073101-073103, геодези 053201, Программ хангамж, түүний хэрэглээ хөгжүүлэлт ба шинжилгээ 0613, Компьютерийн	Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх.	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.

								инженерчлэл 071404, Программ хангамжийн инженерчлэл 071405, Газар зүйн мэдээллийн систем 053202, Байгаль орчны зайнаас тандан судлал 053208.		
--	--	--	--	--	--	--	--	--	--	--